

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/13

Арвайхээр

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах Эрүүл мэндийн алба тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.6 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 347 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам” 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны талаар авах зарим арга хэмжээний тухай” А/418 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тайван үед ажиллах шуурхай удирдлагын нэгжийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, орлон ажиллах албан тушаалтныг гуравдугаар, Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүний ажиллах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүний үйл ажиллагааг журам, төлөвлөгөөний дагуу удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг ерөнхий санхүүч (Б.Валя)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хянапт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/39 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

18900 029  
My Doc.tushaal/EMG/


Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 21.....  
өдрийн 11.2 тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА-ТОХИОЛДЛЫН  
УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Шифр	Гамшгаас хамгаалах албан үүрэг	Албан тушаал
01	Эрүүл мэндийн албаны дарга	Эрүүл мэндийн газрын дарга
02	Штабын дарга менежер	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
03	Тандалтын багийн ахлагч	Эрүүл мэндийн газрын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
04	Төлөвлөлт хяналтын багийн ахлагч	Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга
05	Хариу арга хэмжээний багийн ахлагч	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
06	Эрсдлийн харилцаа холбооны багийн ахлагч	Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга
07	Санхүү нөөцийн багийн ахлагч	Эрүүл мэндийн газрын Ерөнхий санхүүч
08	Хүний нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын багийн ахлагч	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн
09	Штабын нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн газрын гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
10	Мэргэжлийн ангийн дарга	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
11	Зооноз өвчин судлалын багийн ахлагч	Зоонозын өвчин судлалын багийн дарга





Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 21...  
өдрийн А.1.3 тоот тушаалын  
хөрөндугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ТАЙВАН ҮЕД АЖИЛЛАХ  
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Багийн бүрэлдэхүүн	Албан тушаал
1	Менежер	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
2	Зохицуулагч	Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
3	Орон тооны бус гишүүн	Яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн
4	Орон тооны бус гишүүн	Амьсгалын замын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
5	Орон тооны бус гишүүн	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
6	Орон тооны бус гишүүн	Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
7	Орон тооны бус гишүүн	Эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан
	Орон тооны бус гишүүн	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн
8	Орон тооны бус гишүүн	Эдийн засагч
9	Орон тооны бус гишүүн	Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн
10	Орон тооны бус гишүүн	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 21...  
өдрийн 113 тоот тушаалын  
гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАНЫ ТАЙВАН ҮЕД АЖИЛЛАХ  
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ  
ОРЛОН АЖИЛЛАХ АЛБАН ТУШААЛТАН

№	Багийн бүрэлдэхүүн	Албан тушаал	Орлон ажиллах албан тушаал
1	Менежер	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
2	Зохицуулагч	Гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
3	Орон тооны бус гишүүн	Яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн	Уламжлалт анагаах ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн
4	Орон тооны бус гишүүн	Амьсгалын замын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	Орчины эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
5	Орон тооны бус гишүүн	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	Биеийн тамир спортын асуудал хариуцсан мэргэжилтэн
6	Орон тооны бус гишүүн	Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
7	Орон тооны бус гишүүн	Эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан	Олон нийттэй харилцах ажилтан
	Орон тооны бус гишүүн	Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал, ёс зүй хариуцсан мэргэжилтэн
8	Орон тооны бус гишүүн	Эдийн засагч	Нягтлан бодогч
9	Орон тооны бус гишүүн	Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн	Тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
10	Орон тооны бус гишүүн	Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хүүхэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн



Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 04 дүгээр сарын 21...  
өдрийн А/13 тоот тушаалын  
дөрөвдүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА-ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, хянах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг шуурхай удирдан зохион байгуулна.
- 1.2 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь сум орон нутгийн мэргэжлийн ангиудыг удирдлага арга зүйгээр хангана.
- 1.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ хийх, арга хэмжээг төлөвлөх, нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, эрсдлийн харилцаа холбоог зохицуулах, сургалт, дадлага зохион байгуулна.
- 1.4 Аймгийн Онцгой байдлын газар болон бусад албатай хамтарч гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, мэдээлэл солилцох ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.
- 1.5 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байна.
- 1.6 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь дараах зарчимд суурилна. Үүнд:
  - 1.6.1 Нөхцөл байдалтай холбогдуулан өөрчлөлтөд мэдрэг, хувирч ажиллах чадвартай байх
  - 1.6.2 Бүх төрлийн эрсдлийн хариу арга хэмжээнд тохиорсон нэгдсэн бүтэц зохион байгуулалттай байх
  - 1.6.3 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооний бүрэлдэхүүн тайван цагийн албан тушаалын зэрэглэл, шатлал идэвхжлийн үед үйлчлэхгүй байх

### Хоёр. Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн чиг үүрэг

- 2.1 Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх

- 2.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, хянах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг авах үйл ажиллагааны төлөвлөгөө /цаашид Гамшгаас хамгаалах төлөвлөгөө гэх/ боловсруулж Онцгой байдлын газрын дарга болон Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргаар батлуулах
- 2.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн салбарын төсөвт тусгах, зарцуулах, үр дүнг тооцох
- 2.4 Онцгой байдлын үед салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлэх, ажлын тусгай горимд шилжүүлэх, шаардлагатай техник материал хэрэгсэл, голомтод ажиллах мэргэжлийн хүмүүсийг шуурхай томилох
- 2.5 Тайван цагийн болон идэвхжлийн үеийн гэсэн 2 горимд шилжин ажиллана.
- 2.6 Тайван цагийн горимд шуурхай удирдлагын нэгжийн ажиллах чиг үүргийг энэхүү журмаар зохицуулах
- 2.7 Гамшиг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд шаардлагатай мэдээ тайланг холбогдох албад болон сум орон нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх
- 2.8 Үүссэн болон үүсч болзошгүй онцгой нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, мэргэжлийн заавар зөвлөмж, мэдээллээр Аймгийн онцгой комисс болон бусад холбогдох байгууллагуудыг цаг тухайд нь шуурхай хангах, холбогдох шийдвэр гаргуулах
- 2.9 Хууль тогтоомжийн хүрээнд Онцгой байдлын газар болон бусад албад мэргэжлийн ангиудад томилгоот хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах
- 2.10 Халдварын голомтыг халдваргүйтгэх үйл ажиллагаа, хариу арга хэмжээг мэргэжил арга зүйгээр хангах

**Гурав. Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын эрх, үүрэг**

- 3.1 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын бүрэлдэхүүн нь (цаашид штаб гэнэ) Тохиолдлын-Удирдлагын тогтолцооны дарга, штабын дарга (цаашид менежер гэнэ), Яаралтай тусламжийн багийн дарга, Халдварт өвчин судлалын багийн дарга, Зооноз өвчин судлалын багийн дарга, сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан, холбоо, зарлан мэдээлэл



- хариуцсан ажилтан, аюулгүй байдал хариуцсан ажилтан, хангалт хариуцсан ажилтан, мэргэжлийн ангийн дарга нар сонгогчтоор орох бүрэлдэхүүнтэй байна.
- 3.2 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоог ерөнхий удирдлагаар ханган, гамшгийн төлөвлөгөөг баталгаажуулж, холбогдох шийдвэрийг гарган хяналт тавих
- 3.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдалтай холбоотой үүрэг даалгаврыг менежерт, шаардлагатай үед багийн ахлагч нарт өгөх
- 3.4 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрсдэл, хохирол, хэрэгцээний үнэлгээг хийлгэх, эрсдлийг бууруулах, гамшгийн үед салбарын тогтвортой ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах
- 3.5 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын нөөцийг нэгдсэн удирдлагаар хангах
- 3.6 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны штаб бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шийдвэр гаргах
- 3.7 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерийн эрх үүрэг:**
- 3.8 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, мэргэжлийн удирдлагаар хангах
- 3.9 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдалтай холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөх, санал, шийдвэрийн төслийг боловсруулах, холбогдох мэдээ мэдээлэл, тандалтын тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, гамшгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн 7 хоногийн тайлан, өдөр тутмын цагийн байдлын мэдээгээр Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргыг хангах
- 3.10 Шинээр дайчлагдсан ажилтнуудад хийх ажлын чиглэл, удирдамжийг танилцуулах
- 3.11 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны штаб бүрэлдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах
- 3.12 Эрсдлийн үеийн бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянан баталгаажуулах
- 3.13 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны штабын хурлыг 7 хоногт 2 оос доошгүй удаа зохион байгуулж үйл ажиллагааны гүйцэтгэлтэй танилцаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх
- 3.14 Дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүнийг өртөлтийн өмнөх урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах

## **Дөрөв. Төлөвлөлт, хяналтын үйл ажиллагаа**

4.1 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон Гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээ, дадлага

сургуулилтын дүгнэлтэд тулгуурлан шуурхай боловсруулан удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах.

4.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэсэн "тухайн үеийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө"-г 7 хоногоор боловсруулан, баталгаажуулж, хэрэгжилтийг хянах

4.3 Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг менежерээр дамжуулан өдөр тутам авах

4.4 Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох холбогдох багуудыг тооцоолол бүхий мэдээллээр хангах

4.5 Хариу арга хэмжээний явц, үр дүнг тогтмол хянан мэргэжил аргагүйн удирдлагаар хангах

4.6 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тайланг сар бүр багуудаас авч, нэгтгэн, менежерт танилцуулах

## **Тав. Хариу арга хэмжээний үйл ажиллагаа**

5.1 Голомтод хариу арга хэмжээ зохион байгуулах, голомтын халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах, цомхотгох арга хэмжээг авах

5.2 Томилогдон ажиллаж байгаа шуурхай арга хэмжээний баг, мэргэжлийн ангийг ажиллуулах, хувилбаруудыг тооцох, сонгон хэрэгжүүлэх шаардлагатай заавар, зөвлөмж, даалгавар боловсруулж, батлуулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажиллах

5.3 Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын өдөр тутмын бэлэн байдлыг хангуулах, мэдээллээр хангах

## **Зургаа. Эрсдэлийн харилцаа холбооны үйл ажиллагаа**

1.1 Өдөр тутмын хянагдсан мэдээ, мэдээлэл (мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөгөө гм) сайн туршлага, эрсдэлийг даван туулсан түүх зэргийг олон нийт, болон холбогдох байгууллагад мэдээлэх, түгээх

1.2 Хүн амын дундах хандлага, ойлголтын судалгааг хийж, залруулга мэдээлэл бэлтгэн гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашдын чиглэлийг боловсруулах

1.3 Эрүүл мэндийн газрын цахим хуудас, фейсбүүк хуудсаар дамжуулан хүн амыг мэдээллээр тогтмол хангах, зорилтот бүлгийн мэдээллийг хэрэгцээг



тодорхойлох, шаардлагатай мэдээллийг бэлтгэн түгээх, нээлттэй утас ажиллуулах

1.4 Хэвлэлийн бага хурал зохион байгуулах

1.5 Эрүүл мэндийн яаманд үйл явдлын талаарх болон хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээг тогтмол хүргэх

### **Долоо. Санхүү, нөөцийн бэлэн байдал, хангалт, сургалтын үйл ажиллагаа**

7.1 Шаардлагатай хүний нөөцийн судалгааг гарган дайчлан ажиллуулах, хуваарилах

7.2 Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг мөрдөн ажиллах заавар журмаар хангах, түргэвчилсэн сургалт зохион байгуулах

7.3 Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг холбогдох байгууллагуудтай хамтран журамд заагдсны дагуу зохион байгуулах

7.4 Дадлага сургууллт, түргэвчилсэн сургалтад шаардагдах гарын авлага, материалыг харъяа эрүүл мэндийн байгууллагуудад түгээх, олшруулах

7.5 Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж, оношлуурын хэрэгцээ, нөөцийн судалгааг хийх, шаардлагатай төсвийг тооцох нөөцийн мэдээллийг цахим программд шивэх, харъяа эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, тайлан мэдээг гаргах

7.6 Нөөцийг хадгалах, хамгаалахад шаардлагатай агуулах, байр байгууламжийн бэлэн байдлыг хангах, зохицуулах

7.7 Сумын эрүүл мэндийн төвүүдэд нөөцийг түгээх, аюулгүй байдлыг хангах

7.8 Аврах ажилд оролцох, мэргэжлийн ангиудыг шилжүүлэн ажиллуулах, нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр хүнсний болон бусад материалаар найдвартай хангах нөхцлийг судлан хангалтыг хийх

7.9 Урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн бүртгэлд үндэслэн цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал илүү цагийн хөлсийг тооцож олгох

7.10 Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлж, гэрээ хэлцэл хийх, санхүүжүүлэх

7.11 Шаардлагатай худалдан авалтыг хууль журмын дагуу шуурхай зохион байгуулах

### **Найм. Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дотоод үйл ажиллагааны зохицуулалт**

8.1 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дотоод үйл ажиллагааны зохицуулалт нь тайван цагийн ба идэвхжлийн үеийн гэсэн үндсэн

хоёр зохион байгуулалттай байна

- 8.2 Тайван цагийн үед ажиллах Шуурхай удирдлагын нэгж дараахь бүрэлдэхүүнтэй байна. /Тушаалын хоёрдугаар хавсралт/
- 8.3 Шуурхай удирдлагын нэгжийн гишүүд хариуцсан чиг үүргийн хүрээнд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн төлөвлөгөөг төрөл, эрсдлийн түвшинтэй уялдуулан боловсруулах, тодотгол хийх
- 8.4 Үйл явдал болон шалгуур үзүүлэлтэд суурилсан тандалтын мэдээг цуглуулж, нэгтгэн, хариу арга хэмжээний чиглэл, зөвлөмж гарган хэрэгжүүлэх
- 8.5 Нийгмийн эрүүл мэндийн онцгой үйл явдал, осол, аюулт үзэгдлийн бэлэн байдлыг хангахтай холбоотой онолын болон дадлагажуулах сургалт зохион байгуулах
- 8.6 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын хариу арга хэмжээний эргэмж, үнэлгээ хийх, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх
- 8.7 Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны материал бэлтгэн сурталчлах
- 8.8 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах
- 8.9 Тандалт шуурхай удирдлагын нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах
- 8.10 Харьяа эрүүл мэндийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах багуудыг томилон ажиллана
- 8.11 Шуурхай удирдлагын нэгж нь Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай шуурхай мэдээлэл солилцон хамтран ажиллана.
- 8.12 Эрүүл мэндийн алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүн ажлын өдрүүдэд 1 цаг, ажлын бус өдрүүдэд 2 цагийн дотор цугларна.
- 8.13 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь 7/24 цагаар шаардлагатай үед уртасгасан цагаар ажиллана
- 8.14 Тохиолдлын удирдлагын тогтолцоо болон шуурхай удирдлагын нэгжийн бие бүрэлдэхүүнд ажиллах ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй ( эзгүй, эрсдэлд өртсөн гм) тохиолдолд орлон ажиллах ажилтаныг дайчлан ажиллуулна
- 8.15 Уг байр нь хурлын танхим, албан тасалгаа, дотоод сүлжээний өрөө, гал тогооны хэсэгтэй байна. Байрыг тайван цагт цахим хурал, сургалт зохион байгуулахад ашиглана.



8.16 Хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл, байдал үүссэн тохиолдолд шилжүүлэн ажиллуулах нөөц байр болон нүүдлийн төвтэй байна.

8.17 Тайван цагт мэдээлэл солилцох цахим хуудас, тусгайлсан цахим шуудангийн хаяг, суурин утастай байна.

### **Ес. Бусад**

9.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан орон нутгийн гамшгаас хамгаалах томилгоот албан хаагчийг Аймгийн онцгой комиссын дарга болон Онцгой байдлын газрын шагналаар шагнуулах асуудлыг шийдвэрлэнэ.

9.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын голомтод үүрэг гүйцэтгэсэн ажилтны томилолтын зардлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох, мөн сэлгээж амраах, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж болно.

9.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас хамгаалах үүрэг гүйцэтгэх үед хөдөлмөрийн чадвараа түр болон бүрмөсөн алдсан, амь насаа алдсан албан хаагч болон түүний гэр бүлд тэтгэмж, нөхөн олговор олгох асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

9.4 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, техник, хэрэгсэл, хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, бусад албаны дотоод асуудалд оролцуулахыг хориглоно.